



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР

Нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилт
/Тэтгэмж, ажилгүйдлийн даатгалын сангийн
2017 оны хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагааны үр дүн/-нд
хийсэн нийцлийн аудитын тайлан



НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ХӨРӨНГӨД ТАВИХ
ДОТООД ХЯНАЛТ САЙН БАЙНА.

Агуулга:

Тайлан бэлтгэсэн:

Архангай аймаг дахь
Төрийн аудитын газар
Тэргүүлэх аудитор
Д.Уламбаяр
Аудитын менежер
Т.Байгалмаа

Аудитор
Х.Алтанчимэг
Б.Азхүү

2018 оны 04 дүгээр сар

Уг тайланг Аудитын
газрын Вэб сайт-аас
үзнэ үү

www.audit.mn

Аудитын тайлан,
дүгнэлттэй
холбоотой асуудлаар
нэмж тодруулах зүйл
байвал 70332860
дугаарын утас,
70333141 дугаарын
факсаар харилцана уу

Хаяг:
Эрдэнэбулган сум
Аймгийн ЗДТГ-ын байр
3-р давхар 314 тоот

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

АУДИТЫН ТАЙЛАН

ЗОРИЛТ 1. Тэтгэмжийн болон ажилгүйдлийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг хууль тогтоомжтой уялдуулан төлөвлөсөн байна.

1.1 Тэтгэмжийн болон ажилгүйдлийн даатгалын сангийн орлогыг хууль тогтоомжийн дагуу төлөвлөж, хуульд заасан хугацаанд холбогдох газарт хүргүүлэн ажилласан байна.

1.2. Тэтгэмжийн болон ажилгүйдлийн даатгалын сангийн орлогыг хуулинд заасан сангийн эх үүсвэрүүдээс төвлөрүүлэн ажилласан байна.

1.3. Ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн зарим заалтууд орон нутагт бүрэн хэрэгжихгүй байна

ЗОРИЛТ 2. Тэтгэмж болон ажилгүйдлийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт сайн байна.

2.1 Тэтгэмжийн болон ажилгүйдлийн даатгалын сангийн хөрөнгийг хууль журмын дагуу зарцуулж байна.

2.2. Тэтгэмжийн болон ажилгүйдлийн даатгалын сангийн хөрөнгийг сан хооронд шилжүүлж, зориулалтын бусаар зарцуулаагүй байна.

2.3 Сангийн хөрөнгийн зарцуулалтад хийсэн дотоод хяналт шалгалт үр дүнтэй байна.

ДҮГНЭЛТ

ЗӨВЛӨМЖ

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ

Товчилсон үгийн тайлбар:

АРА	Архангай
НА	Нийцлийн аудит
НДҮЗ	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
НДС	Нийгмийн даатгалын сан
НДСОАТТ	Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль
ҮОМШӨД	Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал
ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
НДТХ	Нийгмийн даатгалын тухай хууль
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХЧТАТ	Хөдөлмөрийн чадвараа түр алдсны тэтгэмж
ЖАТ	Жирэмсэн амаржсний тэтгэмж
НД	Нийгмийн даатгал
НДД	Нийгмийн даатгалын дэвтэр
АО	Ажил олгогч

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын нэр:

Нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилт /Тэтгэмж, ажилгүйдлийн даатгалын сангийн 2017 оны хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагааны үр дүн/

Аудитын код: АРА-/2018/01-НА

Аудит хийх үндэслэл:

Аудитыг Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан 2018 оны бүтээгдэхүүн ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилтууд:

Тэтгэмжийн болон ажилгүйдлийн даатгалын сангийн 2017 оны орлого бүрдүүлэлт, зарцуулалт нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдлийн тухай хуулиудтай нийцэж байгаа эсэхийг шалгаж дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан аудитын дүнг холбогдох албан тушаалтанд танилцуулан улмаар орон нутгийн удирдлагад бодит мэдээлэл өгөх, шийдвэр гаргах түвшинд туслалцаа үзүүлэхэд аудитын зорилт оршиж байлаа. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийсэн. Үүнд:

- ✓ Тэтгэмжийн болон ажилгүйдлийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг хууль тогтоомжтой уялдуулан төлөвлөсөн эсэх
- ✓ Тэтгэмжийн болон ажилгүйдлийн даатгалын сангийн хөрөнгийг хууль журмын дагуу зарцуулж, түүнд тавих хяналт үр дүнтэй байгаа эсэх

Аудитын хамрах хүрээ:

Аудитаар Архангай аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн тэтгэмж болон ажилгүйдлийн даатгалын сангийн 2017 оны санхүүгийн болон холбогдох баримт материалыг хамруулан шалгалаа.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Нийцлийн аудитын түр журам арга зүйг ашиглан холбогдох иргэн, хуулийн этгээд, төрийн захиргааны байгууллагын албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга авах, баримт бичгийг судлах зэргээр асуудлын шинжилгээний тохирох аргазүйг ашиглалаа.

Аудитын явцад цуглуулсан баримт материалыг шинжлэхдээ нөхцөл байдлыг хууль, тогтоомжийн үндсэн үзүүлэлттэй харьцуулах, зэрэгцүүлэх, мэдээлэл, нотлох баримтыг бүлэглэх, нэгтгэн дүгнэх, цуглуулсан судалгаа, шинжилгээний баримт материалд дүн шинжилгээ хийх зэрэг аргуудыг ашиглан аудитын хөтөлбөр горимын дагуу шаардлагатай нотлох зүйлсийг цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж санал боловсрууллаа.

Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

- Төсвийн тухай хууль
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль
- Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль
- Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөс гаргасан тушаал, шийдвэрүүд
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд

Үндсэн мэдээлэл

Архангай аймгийн нийгмийн даатгалын санд 2017 онд шимтгэлийн орлогоор 14,944.6 сая төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгээс 15,437.5 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 103.3 хувиар биелүүлсэн байна. Тайлант хугацаанд тэтгэврийн даатгалын санд 31,309.0 сая, тэтгэмжийн даатгалын санд 520.0 сая, эрүүл мэндийн даатгалын санд 185.0 сая, ажилгүйдлийн даатгалын санд **230.0** сая төгрөг нийтдээ улсын төсвөөс 32,244.0 сая төгрөгийн татаас авч, тэтгэврийн даатгалын сангаас 29.1 сая, тэтгэмжийн даатгалын сангаас **25.9** сая, ҮОМШӨД-ын сангаас 545.5 сая, эрүүл мэндийн даатгалын сангаас 878.3 сая, ажилгүйдлийн даатгалын сангаас **59.5** сая төгрөг нийтдээ 1,538.4 сая төгрөгийг төв санд төвлөрүүлсэн байна. Архангай аймгийн нийгмийн даатгалын 5 сангаас 2017 онд давхардсан тоогоор нийт 153749 тэтгэвэр, тэтгэмж, тусламж үйлчилгээ авагчдад 45,833.3 сая төгрөгийн зарцуулалт гарсан бөгөөд үүнээс тэтгэмжийн даатгалын сангаас нийт **2668** даатгуулагчид **1,537.5** сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас **271** даатгуулагчдад ажлаас халагдсаны тэтгэмжид **378.9** сая төгрөг олгосон байна. Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орж, тэтгэмжийн даатгалын сангийн хувь хэмжээ болон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд өөрчлөлт орсон байна.

БҮЛЭГ 1. ТЭТГЭМЖИЙН БОЛОН АЖИЛГҮЙДЛИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХУУЛЬ ТОГТООМЖТОЙ УЯЛДУУЛАН ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.

1.1 Тэтгэмжийн болон ажилгүйдлийн даатгалын сангийн орлогыг хууль тогтоомжийн дагуу төлөвлөж, хуульд заасан хугацаанд холбогдох газарт хүргүүлэн ажилласан байна.

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь НДҮЗ-ийн 2009 оны сарын 5 сарын 26-ны өдрийн 19 тоот тогтоолоор батлагдсан "Нийгмийн даатгалын сангийн төсвийн төсөл, төсөөлөл боловсруулахад баримтлах аргачлал"-ын 1.3¹ дахь заалтын дагуу нийгмийн даатгалын сангийн орлого зарлагын болон нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын ирэх оны төсвийн төсөл, дараагийн 2 оны төсөөллийг боловсруулдаг байна.

2017 оны тухайд: 2016 оны 06 сарын 10-ны өдрийн 1/1073 тоот НДЕГ-ийн албан бичгийн дагуу Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн төсөл, 2018-2019 оны дунд хугацааны төсвийн төсөөллийн мэдэгдлийг хүргүүлж ажилласан байна.

Тус албан бичгийн хүрээнд Төсвийн төсөл боловсруулах, нэгтгэх, хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан төсвийн төсөл, төсөөллийг боловсруулжээ. НДС-ийн орлогыг төлөвлөхдөө ажил олгогчийн тоог 2015 оны гүйцэтгэл 2016 оны эхний улирлын хамрагдалтыг харгалзан төлөвлөсөн байна. Мөн шинээр 3 ААНБ, Төсвийн 3 байгууллага нэмэгдэнэ гэж тооцоолон өмнөх жилээс 6 ААНБ-аар илүү тооцож аймгийн татварын хэлтсээс ААНБ-уудын мэдээллийг бүрэн авч ажиллажээ.

Тэтгэмж болон ажилгүйдлийн орлогын 2017 оны төсвийн төслийн орон нутгаас хүргүүлсэн саналыг НДЕГ-аас 10.8 хувиар нэмэгдүүлж баталсан бол тодотголоор батлагдсан төсвийг 5.9 хувиар бууруулан баталжээ.

Төсвийн төсөлд өгсөн санал батлагдсан төсвийг харьцуулбал дараах байдалтай байна:

Тэтгэмжийн даатгалын сангийн орлогын төлөвлөлт								
№	Орлогын төрөл	Төсвийн төлөвлөлт /санал/	Батлагдсан төсөв	Батлагдсан төсөв/ Төсвийн төсөлд өгсөн санал		Тодотгосон төсөв	Тодотгосон төсөв/Төсвийн төсөлд өгсөн санал	
				Мөнгөн дүн	Хувь		Мөнгөн дүн	Хувь
1	ААНБ-ын АО-ын төлөх шимтгэл	89.8	119.6	29.9	133.3	106.5	16.8	118.8
2	Даатгуулагчийн төлөх шимтгэл	445.6	455.1	9.4	102.1	441.8	(3.80)	99.1
3	Төсөвт байгууллагын төлөх шимтгэл	335.9	408.1	72.2	121.5	363.7	27.8	108.3

¹ "Төсвийн төсөлд өмнөх 2 жилийн гүйцэтгэл, тухайн санхүүгийн жилийн батлагдсан төсөв, хүлээгдэж буй гүйцэтгэл, ирэх 3 жилийн төсвийн төсөл, төсөөллийн мэдээллийг багтаасан байх бөгөөд тоо мэдээлэл, гүйцэтгэл, үнэн зөв, бодитой үзүүлэлт хоорондоо уялдаатай байна.

4	Сайн дурын даатгуулагчийн төлөх шимтгэл	70.1	91.9	21.8	131.1	91.9	21.80	131.1
5	Бусад орлого	0.6	0.3	(0.2)	59.9	0.3	(0.22)	59.9
ТЭТГЭМЖИЙН НИЙТ ДҮН		942.0	1,075.0	133.1	114.1	1,004.3	62.35	106.6
Ажилгүйдлийн даатгалын сангийн орлогын төлөвлөлт								
1	ААНБ-ын АО-ын төлөх шимтгэл	22.4	23.0	0.5	102.4	23.0	0.5	102.3
2	Даатгуугчийн төлөх шимтгэл	110.4	127.6	17.2	115.6	127.1	16.7	115.1
3	Төсөвт байгууллагын төлөх шимтгэл	84.0	82.6	(1.3)	98.4	77.2	(6.8)	91.9
5	Бусад орлого	0.4	0.4	(0.0)	99.3	0.4	(0.0)	99.3
АЖИЛГҮЙДЛИЙН НИЙТ ДҮН		217.2	233.6	16.4	107.6	227.6	10.4	104.8
ДЭЭРХ 2 САНГИЙН НИЙТ ДҮН		1159.2	1308.6	112.8	110.8	1231.9	72.75	106.3

Төсийн төсөлд өгсөн саналыг анх баталсан болон тодотголоор баталсантай харьцуулахад дундажаар НДС-ийн орлогыг 8.3 хувиар нэмэгдүүлж баталсан байна.

1.2 Тэтгэмжийн болон ажилгүйдлийн даатгалын сангийн орлогыг хуулинд заасан сангийн эх үүсвэрүүдээс төвлөрүүлэн ажилласан байна.

2017 онд Аймгийн хэмжээнд НДТХ-ийн 10.1²-т заасан эх үүсвэрүүдээс ажилгүйдлийн болон тэтгэмжийн даатгалын санд 1,297.5 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна. Төвлөрсөн орлогыг тодотголоор батлагдсан төсөвтэй харьцуулахад 5.3 хувиар давж биелэсэн ч нэр төрлөөр нь ангилан харахад ажилгүйдлийн даатгалын орлого тасарсан бөгөөд энэ нь НДС-д хуваарилагдаж байгаа орлогын хуваарилалттай холбоотой байна.

Сангийн төрөл	2016 он			2017 он		
	Төлөвлөгөө /сая төг/	Гүйцэтгэл /сая төг/	Хувь	Төлөвлөгөө /сая төг/	Гүйцэтгэл /сая төг/	Хувь
Тэтгэмж	895.8	941.0	105.0	1004.3	1085.3	108.0
Ажилгүйдэл	223.3	210.2	94.0	227.6	212.2	93.2
Дүн	1119.1	1151.2	102.8	1231.9	1297.5	105.3

Мөн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар дээрх 2 сан 1.8 сая төгрөгийн авлагатай бөгөөд үүнээс 0.4 сая төгрөг нь тэтгэмжийн даатгалын

² 10 дугаар зүйл. Нийгмийн даатгалын сангийн орлогын эх үүсвэр 1. Нийгмийн даатгалын сангийн орлого дор дурдсан эх үүсвэрээс бүрдэнэ: 1/даатгуулагчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэл; 2/ажил олгогчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэл; 3/сангийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүү, үнэт цаасны арилжаанаас олсон орлого; 4/нийгмийн даатгалын шимтгэл төлөх хугацаа хэтрүүлсэнд оногдуулсан алданги; 5/улсын төсвөөс олгох хөрөнгө; 6/бусад эх үүсвэр.

санд, 1.4 сая төгрөг нь ажилгүйдлийн даатгалын санд төвлөрөх орлого байна. Аудитын явцад ажилгүйдлийн даатгалын сангаас 0.6 сая, тэтгэмжийн даатгалын сангаас 0.2 сая төгрөгийн авлагыг тус тус холбогдох санд бүрэн төвлөрүүлсэн байна. Харин ажилгүйдлийн даатгалын сангийн 1 даатгуулагчтай холбоотой 0.7 сая төгрөгийг шүүхээр шийдвэрлүүлэхээр шилжүүлжээ.

Аудитаас ажиглахад НДС-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд нийт 367.0 сая төгрөгийн авлага тайлагнагдсан байсан тул цаашид **Төсвийн тухай хууль болон холбогдох хуулийн хүрээнд өр авлагагүй ажиллахад анхаарах нь зүйтэй байна.**

1.3 Ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн зарим заалт орон нутагт хэрэгжихгүй байна.

А. Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн зарим заалтын хэрэгжилт дараах байдалтай байна. Үүнд:

1. Хуулийн 6.3-т зааснаар ажилгүй болсон иргэд **өөрсдөө хүсвэл** шинээр мэргэжил эзэмших, давтан суралцах хүсэлтээ харьяа дүүргийнхээ хөдөлмөрийн хэлтэст гаргаснаар эрх бүхий байгууллагаас зохион байгуулсан сургалтанд хамрагдаж, сургалтын төлбөрийн тодорхой хувийг НДС-ийн Ажилгүйдлийн даатгалын сангаас Хөдөлмөрийн хэлтэс рүү шилжүүлэх журамтай хэдий ч энэ заалт хөдөө орон нутагт бүрэн хэрэгжихгүй байна.
2. Хуулийн 5-р зүйлд зааснаар ажилгүй болсон даатгуулагч 14 хоногийн дотор оршин суугаа нутаг дэвсгэрийнхээ хөдөлмөр эрхлэлтийн алба, уг бирж байхгүй бол нийгмийн даатгалын байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй бөгөөд энэ заалт нэр төдий хэрэгжиж, зөвхөн ажилгүйдлийн тэтгэмж авахын тулд л хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлэхээр хөдөө орон нутгаас зардал, чирэгдэл болж зорьж ирдэг, харин ажилд орсны дараа хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн бүртгэлээ хасуулдаггүй учир программд бүртгэгдсэн хэвээр байдгаас бүртгэлтэй ажил хайгчийн мэдээ бодитой гардаггүй байх магадлалтай байна.

Иймд хуулийн заалтаар хөдөлмөрийн хэлтэс болон нийгмийн даатгалын байгууллага аль нэгэнд нь бүртгүүлэхээр заасан байгаа тул **хуулийг хэрэгжүүлэх, иргэдэд үйлчлэх төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай, чирэгдэлгүй болгох, ажилгүйдэл, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой мэдээ тайланг үнэн зөв бодитой гаргах, төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулахын тулд Нийгмийн даатгалын хэлтэс болон Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс хамтран зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ авах нь даатгуулагчийн эрх ашигт нийцэхээр байна.**

Б. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль.

Аудитад хамрагдсан тэтгэмжийн даатгалын сангийн хуулийн зохицуулалтыг харахад зарим заалтын хэрэгжилт дараах байдалтай байна. Үүнд:

1. Хуулийн 19³ дүгээр зүйлд тэтгэмжийн даатгалын шимтгэлийг жирэмсний чөлөө авахаас өмнө 12 сараас доошгүй хугацаанд, үүнээс сүүлийн 6 сард нь уг шимтгэлийг тасралтгүй төлсөн даатгуулагч эх жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрхтэй” гэж заасан ч тэтгэмж авагч сайн дурын иргэдийн НДШ-ийн төлөлт тасарсан зарим тохиолдолд шимтгэлийг хэд хэдэн сараар төлсөн мөн төрөхөөс өмнө 6 сар л тасралтгүй төлж ЖАТ-ийг авч байгаа байдал ажиглагдаж байна.

Иймд сайн дурын даатгуулагч нарын тэтгэвэр, тэтгэмжид хамрагдах боломж нөхцөлийг бүрдүүлж, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах үүднээс тэдний НДШ төлөлтийг жигд, тасралтгүй байлгахад анхаарах нь зүйтэй байна. Энэ нь нөгөө талдаа орлогын төвлөрүүлэлтэд эерэг нөлөөтэй байх болно.

БҮЛЭГ 2. ТЭТГЭМЖ БОЛОН АЖИЛГҮЙДЛИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ХӨРӨНГИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛЖ ТҮҮНД ТАВИХ ХЯНАЛТ САЙН БАЙНА.

2.1 Тэтгэмжийн болон ажилгүйдлийн даатгалын сангийн хөрөнгийг хууль журмын дагуу зарцуулж байна.

Ажилгүйдлийн болон тэтгэмжийн даатгалын санд нийт 2102.8 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр нийт 1916.4 сая төгрөг буюу батлагдсан төсвөөс 9.7%-иар дутуу зарцуулсан байна. Тэтгэмжийн орлогыг зарцуулалт тус бүрээр харуулбал:

Тэтгэмжийн даатгалын сан:

2017 онд тэтгэмжийн даатгалын сангаас нийт 2668 даатгуулагчид 1,537.5 сая төгрөг олгосон байна. Үүнээс ХЧТАТ-ийг 1204 иргэнд 101.0 сая, ЖАТ-ийг 1022 иргэнд 994.3 сая төгрөг, Оршуулгын тэтгэмжид 442 иргэнд 442.0 сая төгрөгийг олгожээ. Тэтгэмжийг төрөл тус бүрээр сүүлийн 3 жилээр харуулбал дараах байдалтай байна:

Тэтгэмжийн төрөл	2015		2016		2017	
	хүний тоо	мөнгөн дүн /сая төг/	хүний тоо	мөнгөн дүн /сая төг/	хүний тоо /	мөнгөн дүн /сая төг/
ХЧТАТ	994	90.4	994	80.9	1204	101.0
Жирэмсэн амаржсаны тэтгэмж	902	981.0	915	950.5	1022	994.3
Оршуулгын тэтгэмж	485	300.7	466	388.9	442	442.0
Сангийн бусад зардал	-	0	-	0.1	-	-
Дүн	2381	1372.1	2375	1420.4	2668	1537,5

Эх сурвалж: НДХ-ийн 2017 оны үйл ажиллагааны тайлангаас

³ 1.Тэтгэмжийн даатгалын шимтгэлийг жирэмсний чөлөө авахаас өмнө 12 сараас доошгүй хугацаанд, үүнээс сүүлийн 6 сард нь уг шимтгэлийг тасралтгүй төлсөн даатгуулагч эх жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрхтэй.

Аудитаар Эрдэнэбулган сумын 111 даатгуулагчийн 111.0 сая төгрөгийн оршуулгын тэтгэмжийг, 327 даатгуулагчийн 309.3 сая төгрөгийн ЖАТ, 105 даатгуулагчийн 17.4 сая төгрөгийн ХЧТА тэтгэмжийн тооцооллыг нэг бүрчлэн тулган шалгаж анхан шатны нотлох баримтаар баталгаажуулахад дараах асуудлууд илэрлээ. Үүнд:

1. 2-р сард ЖАТ- авагч 9 иргэний 13.7 сая, ХЧТАТ авагч 4 иргэний 0.4 сая төгрөгийн тэтгэмжийг олгохдоо НДС-аас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 23.5⁴ дахь заалтыг зөрчиж 2-5 хоногоор хэтрүүлэн олгосон нь НДС-ийн санхүүжилт оройтож орж ирсэнтэй холбоотой байна..
2. Аудитаар тооцсон 18 даатгуулагчтай холбоотой 17.1 сая төгрөгийн тэтгэмж НД-ын байцаагчийн тооцсон дүнгээс зөрүүтэй байсныг НД-ын программаар тулган баталгаажуулалт хийлээ. Зөрүү нь ЖАТ авагч иргэдийн НДД-т бичилт хийсэн цалин хөлс түүнтэй адилтгах хөлсөөр тэтгэмжийг тооцож авахаар тооцооллыг хийхэд НД-ын программаар үндсэн ажлаас гадуур давхар цалин түүнтэй адилтгах хөлс авсан дүн бичигдэхгүй байгаатай холбоотой байна.
3. Аудитаар 11-12 сарын сайн дурын даатгуулагчийн тэтгэмж олголтыг түүвэрлэн шалгахад 29 иргэний 6.9 сая төгрөгийн тэтгэмжийг олгохдоо анхан шатны баримт болох өргөдлийг гаргуулалгүй олгосон байна. Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 “Даатгуулагчийн өргөдөл, хуульд заасан бусад баримт бичгийг үндэслэн даатгуулагчид тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох тухай шийдвэрийг нийгмийн даатгалын байгууллага гаргана” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Ажилгүйдлийн даатгалын сан

2017 онд ажилгүйдлийн даатгалын сангаас нийт 271 даатгуулагчдад 378.9 сая төгрөгийн тэтгэмжийг олгосон байна. Тэтгэмжийн төрөл тус бүрээр сүүлийн 3 жилээр харуулбал дараах байдалтай байна:

Тэтгэмжийн төрөл	2015		2016		2017	
	хүний тоо	мөнгөн дүн /сая төг/	хүний тоо	мөнгөн дүн /сая төг/	хүний тоо /	мөнгөн дүн /сая төг/
Ажилгүйдлийн даатгалын сан	157	140.4	273	276.4	271	378.9
Дүн	157	140.4	273	276.4	271	378.9

Эх сурвалж: НДХ-ийн 2017 оны үйл ажиллагааны тайлангаас

Хүснэгтээс харахад 2017 онд ажилгүйдлийн тэтгэмж авагч иргэдийн тоо өмнөх онтой харьцуулахад нэмэгдсэн байхад харин олгосон тэтгэмжийн дүн мөн

⁴ Нийгмийн даатгалын байгууллага тэтгэмж авах өргөдлийг хүлээж авснаас хойш хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны тэтгэмж олгох асуудлыг 21 хоногийн дотор, оршуулгын тэтгэмж олгох асуудлыг 24 цагийн дотор шийдвэрлэнэ.

адил нэмэгдсэн байгаа нь 2017 оны 01 сараас эхлэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 192.0-240.0 мянган төгрөг болж өссөнтэй холбоотой байна. Мөн 2016-2017 онуудад тэтгэмж авагч иргэдийн тоо өссөн нь орон нутгийн болон УИХ-ын сонгуультай холбоотой гэж үзэж болохоор байна.

Аудитаар 11 сумын 200 даатгуулагчийн 260.8 сая төгрөгийн тэтгэмж олголт, тогтоолт, хувийн хэргийн бүрдүүлэлтийг хянаж үзэхэд дараах зөрчилтэй асуудал илэрлээ. Үүнд:

1. НДҮЗ-ийн 2016 оны 07 сарын 22-ны өдрийн 22-р тогтоолын 4.7⁵-д зааснаар 2 даатгуулагчтай холбоотой хууль бусаар халагдсан нь шүүхээр тогтоогдож, түүний ажилгүй байсан хугацааны цалинг нөхөн олгож, НДШ-г зохих санд буцаан төвлөрүүлсэн ба тухайн даатгуулагчийн ажилгүй байх хугацаанд олгосон **3.0** сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг буцаан төвлөрүүлэх шийдвэр гаргасныг хэрэгжүүлээгүй байна. /Хавсралт төлбөрийн актаар/
2. НДҮЗ-ийн 2016 оны 07 сарын 22-ны өдрийн 22-р тогтоолын 2.1⁶-д зааснаар ажил хийхэд бэлэн, ажил идэвхитэй хайж байгаа, хөдөлмөрийн насны иргэнд ажилгүйдлийн тэтгэмж олгоно гэсний дагуу Төрийн албаны тухай хуулийн **23.3.1⁷** дэхь заалтын дагуу ажлаас **түр чөлөөлөгдсөн** 2 даатгуулагчид 4.8 сая төгрөгийг олгосон байна. Үүнийг аудитын зүгээс харахад төрийн албаны тухай хуулийн дагуу түр чөлөөлөгдсөн гэдэг нь тухайн хүний ажлын байр хадгалагдаж байна гэж ойлгогдож байгаа бөгөөд ийм тохиолдолд дээрх журмын заалтаар тухайн хүнийг “ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайгч, хөдөлмөрийн насны иргэн...” гэж үзэх нь учир дутагдалтай байна. Иймд ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн дээрх заалтын хээргжилтийн бодит нөхцөл байдлын талаар саналаа ҮАГ-аар дамжуулан холбогдох газарт уламжлуулах болно.

2.2 Тэтгэмжийн болон ажилгүйдлийн даатгалын сангийн сангийн хөрөнгийг сан хооронд шилжүүлж, зориулалтын бусаар зарцуулаагүй байна.

Тэтгэмж болон ажилгүйдлийн даатгалын сангаас хийсэн Төрийн болон Хаан банкны гүйлгээнүүдийг түүвэрлэн шалгахад Нийгмийн даатгалын тухай хуулийн 11.2⁸ дугаар заалт зөрчигдөж 1.1 сая төгрөгийн хөрөнгө хоорондоо шилжиж зарцуулагдсаныг тухайн үед нь бус сар улирлын эцэст залруулсан байна.

⁵ Даатгуулагчийн хууль бусаар ажлаас халагдсаныг шүүхээс тогтоож, түүний ажилгүй байсан хугацааны цалинг нөхөн олгож, ногдох нийгмийн даатгалын шимтгэлийг ажил олгогч нь Нийгмийн даатгалын тухай хуульд заасан хувь хэмжээгээр тооцож зохих санд төлсөн тохиолдолд тухайн даатгуулагчийн ажилгүй байх хугацаанд авсан ажилгүйдлийн тэтгэмжийг санд буцаан төлүүлж тооцоо хийнэ.

⁶ Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль-ийн 2 дугаар зүйлд заасан нөхцөл, болзлыг хангасан, “ажил хийхэд бэлэн, ажил идэвхитэй хайж байгаа, хөдөлмөрийн насны иргэн”-д ажилгүйдлийн тэтгэмж олгоно.

⁷ 23.3.Төрийн жинхэнэ албан хаагчийг дараахь үндэслэлээр захиргааны санаачилагаар төрийн албанаас түр чөлөөлнө: 23.3.1.хуульд өөрөөр заагаагүй бол биеийн эрүүл мэндийн байдлын улмаас 1 жилээс дээш хугацаагаар албан ажлаа хийхгүйгээр эмчлүүлж, сувилуулах шаардлагатай болсон.

⁸ 2.Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг сан хооронд шилжүүлэн зарцуулах, зориулалтын бус чиглэлээр ашиглах, байршуулахыг хориглоно.

Сан хооронд шилжүүлсэн ажил гүйлгээ

№	Сан хооронд шилжүүлсэн ажил гүйлгээ		Тухай ажил гүйлгээний зардлыг		Ажил гүйлгээг залруулсан огноо
	Огноо	Мөнгөн дүн	Шилжүүлэх ёстой сангийн нэр	Шилжүүлсэн сангийн нэр	
1	2017.02.01	91.1	Тэтгэмжийн даатгалын сан	Ажилгүйдлийн даатгалын сан	2017.04.19
2	2017.07.24	31.4	Тэтгэмжийн даатгалын сан	Ажилгүйдлийн даатгалын сан	2017.08.02
3	2017.07.29	31.4	Тэтгэмжийн даатгалын сан	Ажилгүйдлийн даатгалын сан	
5	2017.02.14	317.5	Ажилгүйдлийн даатгалын сан	Тэтгэмжийн даатгалын сан	2017.03.02
6	2017.02.14	183.5	Ажилгүйдлийн даатгалын сан	Тэтгэмжийн даатгалын сан	2017.03.21
7	2017.03.16	167.0	Ажилгүйдлийн даатгалын сан	Тэтгэмжийн даатгалын сан	2017.03.21
8	2017.03.31	317.5	Ажилгүйдлийн даатгалын сан	Тэтгэмжийн даатгалын сан	2017.04.25
ДҮН		1,139.4			

Харин сумдаас төвлөрүүлдэг шилжүүлгийн гүйлгээг хийхдээ сан андуурч хийдэг асуудал байсан бөгөөд залруулгыг тухай бүр хийж, холбогдох сан руу шилжүүлдэг бөгөөд өөрөөр сангийн хөрөнгийг зориулалт бусаар болон сан хооронд гүйлгэн зарцуулах зэрэг асуудал илрээгүй болно.

2.3 Сангийн хөрөнгийн зарцуулалтад хийсэн дотоод хяналт шалгалт үр дүнтэй байна.

Тэтгэмжийн болон ажилгүйдлийн даатгалын санд 2017 онд төлөвлөгөөт шалгалт хийгдээгүй ч тэтгэмжийн бодолт олголтонд НД-ийн улсын байцаагч улирал бүр дотоод хяналт шалгалтыг хийж ажиллаж байна. Тайлант онд 26 тэтгэмж авагчтай холбоотой 4.3 сая төгрөгийн төлбөр барагдуулах акт тогтоож үүнээс 34 тэтгэмж авагчийн 11.2 сая төгрөгийг барагдуулсан, 2 тэтгэмж авагчийн 1.1 сая төгрөгийн төлбөрийн актыг барагдуулаагүй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

№	Шалгалтын төрөл	Үзүүлэлт	Оны эхний үлдэгдэл	Тайлангийн хугацаанд		Эцсийн үлдэгдэл
				Шалгаж илрүүлсэн төлбөрийн дүн	Барагдуулсан дүн	
1	Тэтгэмжийн бодолт олголт/ ЖА, ХЧТА, Ажилгүйдэл, Оршуулга	Хүний тоо	10	26	34	2
		Мөнгөн дүн	8.1	4.3	11.2	1.1

Эх сурвалж: НДХ-ийн 2017 оны үйл ажиллагааны тайлангаас

Үүнээс 2017 онд ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж авсан 8 иргэнд онд 4.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож биелэлтийг хангуулан ажилласан байна. Үүнээс оны эцэст 3 ажилгүйдлийн тэтгэмж авагчийн 1.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ч аудитад баримт материал шалгагдах хугацаанд 0.6 сая төгрөг бүрэн барагдаж 0.7 сая төгрөгийн тэтгэмж шүүхийн шийдвэрийг хүлээж байна. 2017 онд тэтгэмжийн даатгалын санд 0.4 сая төгрөгийг төвлөрүүлэх акт тогтоогдсон бөгөөд аудитад хамрагдах хугацаанд 0.3 сая төгрөгийн акт бүрэн барагдаж 0.1 төгрөгийн акт барагдах шатандаа явж байна.

Харин НДСОАТХ-нд тэтгэмжийг сард 2 удаа олгохоор заасан боловч сумдын тухайд зарим тохиолдолд бөөн дүнгээр олгодог, олгохоор төсөвлөсөн хуваарийн дагуу олгодоггүй, ажилд орсон тохиолдолд тэтгэмжийг зогсоогоогүй зэрэг зөрчлүүд илэрч нийгмийн даатгалын хяналтын улсын байцаагч өөрийн бүрэн эрхийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох баримт, аудитаас хэрэгжүүлэх зорилтын хүрээнд дараах дүгнэлтийг хийлээ.

Тэтгэмжийн болон ажилгүйдлийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг хууль тогтоомжтой уялдуулан төлөвлөсөн байна.

1.1 Тэтгэмжийн болон ажилгүйдлийн даатгалын сангийн орлогыг хууль тогтоомжийн дагуу төлөвлөж, хуульд заасан хугацаанд холбогдох газарт хүргүүлэн ажилласан байна.

1.2. Тэтгэмжийн болон ажилгүйдлийн даатгалын сангийн орлогыг хуулинд заасан сангийн эх үүсвэрүүдээс төвлөрүүлэн ажилласан байна.

1.3 Ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн зарим заалтууд орон нутагт бүрэн хэрэгжихгүй байна

Тэтгэмж болон ажилгүйдлийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт сайн байна.

2.1 Тэтгэмжийн болон ажилгүйдлийн даатгалын сангийн хөрөнгийг хууль журмын дагуу зарцуулж байна.

2.2. Тэтгэмжийн болон ажилгүйдлийн даатгалын сангийн хөрөнгийг сан хооронд шилжүүлж, зориулалтын бусаар зарцуулаагүй байна.

2.3 Сангийн хөрөнгийн зарцуулалтад хийсэн дотоод хяналт шалгалт үр дүнтэй байна

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн зарим заалтуудыг зохистой хэрэгжүүлж, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах үүднээс холбогдох зөвлөмжийг Аймгийн хөдөлмөр халамж, үйлчилгээний хэлтэст мөн адил хүргүүлэх болно.

1. Даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах үүднээс Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийг хуулийн дагуу олгохын тулд Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэстэй ажлын уялдаа холбоотой ажиллах.
2. Нийгмийн даатгалын тухай хуулийн 8.1-д заасны дагуу сайн дурын даатгуулагч нарт холбогдох тэтгэвэр тэтгэмжийг олгохдоо анхан шатны баримтын бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах.
3. Төсвийн тухай хуулийн 6.4.8-д заасны дагуу өр авлагагүй ажиллахад анхаарах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлснээр Нийгмийн даатгалын тухай хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан салбар хуулийн заалтууд бүрэн хэрэгжиж, иргэдэд үйлчлэх төрийн үйлчилгээ улам хөнгөн шуурхай чирэгдэлгүй болж, ажилгүйдэл, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой мэдээ тайланг үнэн зөв бодитой гарах, төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо улам сайжирч, даатгуулагчийн эрх ашигт нийцэх болно.

Зөвлөмжийн хариуг 2018 оны 06 сарын 30-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.